



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/323

Бсөнбулаг

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.7 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Говь-Алтай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг олон нийтэд тайлагнах зорилгоор хэвлэл мэдээллийн Erennews.mn сайттай шууд гэрээ байгуулах эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т шилжүүлж, зардлыг хавсралтаар баталсугай.

2. Шаардагдах 8.000.000 (найман сая) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын
2024 оны 05 дугаар сарын 22 -ны
өдрийн 1123 дугаар захирамжийн
хавсралт

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН
ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ, ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ ТАЙЛАГНАХ

№	Төсөл арга хэмжээний нэр	Эрх шилжүүлсэн байгууллага	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг
1.	Говь-Алтай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг олон нийтэд тайлагнах зорилгоор хэвлэл мэдээллийн Etennews.mn сайттай шууд гэрээ байгуулах	АЗДТГ	2024.04	2024.10	
Нийт дүн					8.000.000

__oOo__

